

Орчуулга

**Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)-ыг
хэрэгжүүлэх дүрэм**

"Япон Улс, Монгол Улс хоорондын Нүүрстөрөгч Багатай Хөгжлийн Түншлэл"-д зааснаар ХКОМ-ын Хамтарсан Хороо нь үүгээр ХКОМ-ыг хэрэгжүүлэх дүрмийг дараах байдлаар тогтоов:

А. ХКОМ-ын зорилго

1. ХКОМ нь дараах зорилготой:

- a) Нүүрстөрөгч багатай тэргүүлэх технологи, бүтээгдэхүүн, систем, үйлчилгээ болон дэд бүтцийг дэмжих мөн Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах;
- b) Монгол Улсад хэрэгжүүлж буй бууруулах/ангиржуулах ажлын үр дүнд хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг Япон Улсын талаас тоон хэлбэрээр тооцуулах, ингэснээр хоёр улсын хүлэмжийн хийг бууруулах зорилгод хүрэх;
- c) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Суурь Конвенцын (НҮБУАӨСК)-ын зорилго болон даян дэлхийн ялгарлыг бууруулах, ангиржуулахад хувь нэмэр оруулах;

В. Хамрах хүрээ

2. Хүлэмжийн хий нь нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂), метан (CH₄), азотын исэл (N₂O), гидрофторт нүүрстөрөгч (HFCs), перфторт нүүрстөрөгчийн нэгдлүүд (PFCs), 6 фторт хүхэр (SF₆), 3 фторт азот (NF₃) нараас бүрддэг.

3. ХКОМ-ын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ангиржуулах төслийн (цаашид "ХКОМ-ын төслүүд" гэх) үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төсөлд оролцогчдын оруулсан хувь нэмэр, кредитийн хугацаанд бий болсон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан болон ангиржуулсан тоон хэмжээнд

үндэслэн кредит олгоно.

4. Кредит олгох хугацаа нь тогтмол 10 жил эсвэл 5 жилийн хугацаатай шинэчилж болох кредит байх бөгөөд доорх 51 дүгээр зүйлд зааснаар тухайн хугацааг хэтрүүлэхгүйгээр аль аль нь хамгийн ихдээ 2 удаа шинэчилж болно.

5. ХКОМ нь үл худалдаалагдах төрлийн кредит олгох механизм гэдгээр үйл ажиллагаагаа эхлэх бөгөөд цаашид Япон, Монголын талууд (цаашид "талууд" гэх) худалдаалагдах төрлийн кредит олгох механизм руу шилжүүлэх талаар зөвшилцөж, ХКОМ-ын хэрэгжилтийг харгалзан аль болох богино хугацаанд шийдвэрийг гаргана.

С. Хамтарсан Хороо

6. Талууд хоёр талын Засгийн газрын төлөөллөөс бүрдсэн Хамтарсан Хороог байгуулна.

7. Хамтарсан Хороо нь Хэрэгжилтийн Дүрмийг болон ХКОМ-ыг хэрэгжүүлэхэд бусад шаардлагатай дүрэм журмыг боловсруулах, өөрчлөлт оруулах эрхтэй. Үүнд:

- a) Хамтарсан Хорооны үйл ажиллагааны дүрэм
- b) Аргачлалыг боловсруулах журам
- c) Аргачлал
- d) Гуравдагч талыг томилох журам
- e) Баталгаажуулах журам
- f) Хяналтын журам
- g) ХХЯ-ын бууралтыг шалгах журам
- h) Бүртгэлийн нийтлэг үзүүлэлтүүд
- i) Төслийн баримт бичгүүд (цаашид ТББ гэх), тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө (цаашид **ТХОХНТө** гэх), ХКОМ-ын төслөөр бүртгүүлэх хүсэлт, хяналт-шинжилгээний тайлан, тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайлан (цаашид **ТХОХНТа** гэх), хүлэмжийн хийн ялгарлын бууралт, ангижралтыг шалгах хүсэлт гэх зэрэг.

- j) Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө болон тайлан боловсруулах журам.

8. Хамтарсан Хороо нь Гуравдагч талын этгээдийг томилно.

9. Төсөлд оролцогч талуудын ХКОМ-ын төслөөр бүртгүүлэх хүсэлтэд үндэслэн Хамтарсан Хороо нь Гуравдагч талын этгээдээр баталгаажсан ХКОМ-ын төслүүдийг бүртгэнэ.

10. Төсөлд оролцогч талуудад кредит олгосонтой холбоотой хоёр талд мэдэгдэхийг хүссэн хүсэлтийн дагуу Хамтарсан Хороо нь Гуравдагч талын этгээдээр нотлогдсон баримтад үндэслэн кредит олгосон мэдэгдлийг талуудад мэдээлнэ.

11. Хамтарсан Хороо нь ХКОМ-ын хэрэгжилтийн тайланг боловсруулж, шаардлагатай тохиолдолд ХКОМ-ын үйл ажиллагаа, удирдлагатай холбоотой асуудлыг хэлэлцэнэ.

12. Хамтарсан Хорооны хурлын үеэр талууд ХКОМ-ын холбогдох бодлогын арга хэмжээний талаар зөвлөлдөнө.

13. Хамтарсан Хороо нь ХКОМ-ыг хэрэгжүүлэх нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулан ажиллана.

D. Талууд

14. Хамтарсан Хорооноос боловсруулан гаргасан дүрэм журмыг үндэслэн мөн холбогдох улс орнуудын дотоод хууль тогтоомжийн хүрээнд тал тус бүр:

- a) Аргачлалын төслийг боловсруулж Хамтарсан Хороонд өгнө.
- b) Хамтарсан Хорооноос гаргасан бүртгэлийн нийтлэг үзүүлэлтүүдийн дагуу бүртгэлийг үүсгэн хөтөлнө.
- c) Хамтарсан Хорооноос кредит олголтын тухай мэдэгдлийг үндэслэн (төсөлд оролцогч талуудын дунд хуваарилсан кредитийг оруулан) тухайн зөвшөөрсөн хэмжээний кредитийг олгоно.

15. Тал тус бүр ХКОМ-ын төслийн хүрээнд кредит олгосон талаар

Хамтарсан Хороонд нэн дариу мэдэгдэнэ.

16. Тал тус бүр ХКОМ-ын хэрэгжилтийн ил тод байдлыг хангах үүднээс шаардлагатай арга хэмжээг авна.

17. Тал тус бүр давхар тоолохоос сэргийлэх үүднээс ХКОМ-д бүртгэлтэй төслийн бууралтыг бусад олон улсын уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах механизмын зорилгоор ашиглаж үл болно.

18. Японы тал ХКОМ-ын хүрээнд хэрэгжиж буй төслүүдийг урамшуулах хөтөлбөр хэрэгжүүлж буй тохиолдолд тухайн хөтөлбөрийг хэрэгжиж эхэлсэн дариу Монгол Улсын талд мэдэгдэнэ.

Е. Гуравдагч талын этгээд

19. Хамтарсан Хорооны баталсан гуравдагч талын этгээд нь:

- a) Төсөлд оролцогч талуудын хүсэлтэд үндэслэн Хамтарсан Хорооноос боловсруулсан магадалгааны удирдамжийн дагуу төсөлд оролцогч талуудын бэлдэн ирүүлсэн ТББ-д тодорхойлсон төслийг баталгаажуулан, үр дүнг төсөлд оролцогч талуудад мэдээлэх;
- b) Төсөлд оролцогч талуудын хүсэлтэд үндэслэн ХКОМ-ын төслийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ангижруулах үйл ажиллагааг шалгах удирдамжийн дагуу төсөлд оролцогч талуудын бэлдэн ирүүлсэн хяналт-шинжилгээний тайланд тодорхойлсон ХХЯ-ын бууралт, ангижруулалтыг нотлох ажлыг Хамтарсан Хорооны боловсруулсан хяналт-шинжилгээний журмын дагуу шалгаж, үр дүнг хяналт-шинжилгээний тайланд тусган төсөлд оролцогч талуудад илгээнэ.

Ү. Төсөлд оролцогч талууд

20. Төсөлд оролцогч талууд:

- a) Аргачлалын төслийг бэлдэн төслийг Хамтарсан Хороогоор батлуулах;

- b) ТХОХНТө-ний маягыг бөглөн ТХОХНТө-ний баримт бичгийг бэлдэн нарийн бичгийн газарт илгээн хянуулах;
- c) ТББ-ийн төслийг бэлдэн баталгаажуулахаар гуравдагч талын этгээдэд хүргүүлэн, Хамтарсан Хороонд мэдэгдэх;
- d) ТББ-ийг Гуравдагч талын этгээдээр баталгаажуулсны дараа Хамтарсан Хороонд хүргүүлж төслийн бүртгүүлэх;
- e) ХКОМ-ын төслийг хэрэгжүүлэх, ТББ-ын дагуу хяналт-шинжилгээг хийх;
- f) Хяналт-шинжилгээ хийх хугацаа бүрд ТХОХНТа-г бэлдэн, ТХОХНТа-ийн маягыг бөглөн нарийн бичгийн газарт илгээн хянуулах;
- g) Хяналт-шинжилгээ хийх хугацаа бүрд хяналт-шинжилгээний тайланг бэлдэн гуравдагч талын этгээдээр нотлуулах;
- h) Гуравдагч талын этгээдийн баталгаажин, нотлогдсон Хамтарсан Хороонд илгээн ХКОМ-ын кредит олгох тухай хүсэлтийн талаар тал тус бүрд мэдэгдэх.

G. Аргачлал боловсруулах

21. Тал тус бүр эсвэл төсөлд оролцогч талууд аргачлалын төслийг бэлдэн Хамтарсан Хороонд илгээнэ. Аргачлалын төслийн бүрэн гүйцэт байдлыг шалгасны дараа олон нийтийн санал асуулгыг авна.

22. Хамтарсан Хороо нь илгээсэн материалыг үндэслэн аргачлалын төслийг батлах эсвэл татгалзах бөгөөд үр дүнг тал тус бүрд эсвэл төсөлд оролцогч талуудад мэдэгдэнэ. Хамтарсан Хороо нь тухайн төслийн төрөл, технологийн төрлийн эерэг жагсаалтыг илэрхийлсэн батлагдсан аргачлалын талаарх холбогдох мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй болгоно.

H. Гуравдагч Талын Этгээдийн томилгоо

23. Хамтарсан Хороо нь гуравдагч талын этгээдээр бүртгүүлэх хүсэлтийн өргөдлийг хүлээн авсны дараа гуравдагч талын этгээдийг томилох журмын дагуу томилон, томилогдсон эрх бүхий гуравдагч талын этгээдийн холбогдох мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд

ил байршуулна.

24. Хамтарсан Хороо нь гуравдагч талтай холбоотой залилан мэхлэлт, хууль бус үйлдэл эсвэл чадваргүй байдлын тухай олж мэдсэн тохиолдолд тухайн гуравдагч талын этгээдийг түдгэлзүүлж томилгоог цуцлах эрхтэй.

I. Баталгаажуулалт

25. Баталгаажуулалт гэдэг нь санал болгож буй ХКОМ-ын төслийн баримт бичигт үндэслэн Хамтарсан Хорооноос боловсруулсан баталгаажуулалтын журмын эсрэг хөндлөнгөөс гуравдагч талын этгээд бие даасан үнэлгээ хийх үйл явцыг хэлнэ.

26. Төсөлд оролцогч талууд маягтыг бөглөн ТББ-ийг боловсруулан, санал болгож буй ХКОМ-ын төслийг гуравдагч талын этгээдээр баталгаажуулах хүсэлт гаргана.

27. Гуравдагч талын этгээд Хамтарсан Хорооноос боловсруулсан баталгаажуулалтын журмын дагуу санал болгож буй ХКОМ-ын төслийг ТББ-д тодорхойлсны дагуу баталгаажуулж үр дүнг төсөлд оролцогч талуудад мэдэгдэнэ.

J. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөг хянах

28. Төсөлд оролцогч талууд тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө/тайлангийн удирдамжийн дагуу ТХОХНТө-ний маягтыг бөглөн бэлдэж төслийн үе шатны журмын дагуу ТХОХНТө-г Нарийн бичгийн дарга нарын газарт илгээнэ.

29. Нарийн бичгийн дарга нарын газар төсөлд тогтвортой хөгжилд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл тодорхойлогдсон эсэх, зохих үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан эсэхийг хянан, шалгах хугацаа дуусахад төсөлд оролцогч талуудад мэдэгдэнэ.

K. Бүртгэл

30. Бүртгэл гэдэг нь ХКОМ-ын баталгаажуулсан төслийг Хамтарсан Хорооноос албан ёсоор хүлээн зөвшөөрснийг хэлнэ.

31. Төсөлд оролцогч талууд гуравдагч талын этгээдээр баталгаажуулсан ТББ болон эерэг үнэлгээ авсан ТХОХНТө-г Хамтарсан Хороонд илгээж төслөө бүртгүүлэх хүсэлтийг гаргана.

32. Хамтарсан Хороо төсөлд оролцогч талуудаас бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авсан даруйд төслийг бүртгэн, бүртгэлийн талаар мэдэгдлийг тал тус бүрд мэдэгдэж, ХКОМ-ын төслийн холбогдох мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй болгоно.

I. Хяналт-шинжилгээ

33. Төсөлд оролцогч талууд ХКОМ-ын төслийг хэрэгжүүлж, ТББ-т тусгасны дагуу ХКОМ-ын төслийн хүлэмжийн хийн ялгарлын бууралт эсвэл ангижралтад хяналт-шинжилгээ хийнэ.

M. Нотолгоо

34. Нотолгоо гэдэг нь нотолгооны хугацаанд бүртгэгдсэн ХКОМ-ын төслийн хэрэгжилтийн үр дүнд хянагдсан хүлэмжийн хийн ялгарлын бууралт эсвэл шингээлтийг гуравдагч талын этгээд бие даасан байдлаар тогтмол хянаж, тодорхойлохыг хэлнэ

35. Төсөлд оролцогч талууд хяналт-шинжилгээний тайланг бэлтгэн гуравдагч талын этгээдээр нотлуулах хүсэлт гаргана.

36. Гуравдагч талын этгээд нь Хамтарсан Хорооноос боловсруулан баталсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ангижруулах үйл ажиллагааг шалгах журмын дагуу төсөлд оролцогч талуудаас ирүүлсэн хяналт-шинжилгээний тайланд үндэслэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ангижруулах хэмжээг нотолж, нотолгооны тайланг бэлдэн, хүсэлт гаргасан төсөлд оролцогч талуудад тайланг илгээнэ.

N. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайлангийн үнэлгээ

37. Төсөлд оролцогч талууд Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө/тайланг боловсруулах журмын дагуу ТХОХНТа-ын маягыг бөглөн, эерэг үнэлгээ авсан ТХОХНТө-ний төслийн үйл ажиллагааны

хугацаанд нарийн бичгийн дарга нарын газарт тайланг ирүүлнэ.

38. Үнэлгээний хугацаа дуусахад нарийн бичгийн дарга нарын газар нь төслийн тогтвортой хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөлөл илрүүлсэн тохиолдолд засаж, залруулах арга хэмжээний талаар зохих тайлбар хийлгүйгээр төсөлд оролцогч талуудад мэдэгдэнэ.

О. Кредит олгох

39. Тал тус бүр Уур Амьсгалын Өөрчлөлтийн асуудлаарх Засгийн Газар Хоорондын Зөвлөл (IPCC)-өөр үнэлдэг хэмжилтийн арга зүйн дагуу нүүрстөрөгчийн давхар исэлтэй дүйцэх (т/CO₂) метр тонн-оор хэмжигдсэн кредитийг бүртгэх, ашиглах системийг бий болгож ажиллана.

40. ХКОМ-ын төсөлд оролцогч талууд хоорондоо зөвлөлдөх байдлаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ангижруулахад оруулсан хувь нэмрийг харгалзан үзэж кредитийн хуваарилалтыг тодорхойлно.

41. Төсөлд оролцогч талууд кредитийн тодорхой хэсгийг зохих талуудад хуваарилж болно.

42. Төсөлд оролцогч талууд хуваарилагдсан кредитийн хэмжээг тусгасан нотолгооны тайланд үндэслэн, кредитийг бүртгэлд буй зохих дансанд олгон/байршуулж, талуудад мэдэгдэх тухай хүсэлтийг Хамтарсан Хороонд гаргана.

43. Хамтарсан Хороо нь төсөлд оролцогч талуудаас ирүүлсэн кредит хуваарилалт, кредит олох хүсэлтийн баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг шалган, үр дүнг талуудад мэдэгдэнэ.

44. Хамтарсан Хороо нь кредит олгосон талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Р. Кредитийн хэрэглээ

45. Талууд холбогдох зохицуулалтыг үндэслэн давхар тоолохоос сэргийлсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтын хүрээнд олгосон кредитийг ашиглана.

46. Япон талын ХКОМ-ын бүртгэлд олгосон ХКОМ-ын кредитийг тал тус бүр үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр болон олон улсын ялгарлыг бууруулах зорилтын хүрээнд хэрэглэхийг зөвшөөрнө.

47. Монгол талын ХКОМ-ын бүртгэлд олгосон ХКОМ-ын кредитийг Монголын тал олон улсын ялгарлыг бууруулах зорилт болон Монгол Улсын талаас тодорхойлсон бусад зорилтод ашиглахыг зөвшөөрнө.

48. Япон талын ХКОМ-ын бүртгэлд олгосон ХКОМ-ын кредит болон Монгол талын ХКОМ-ын бүртгэлд олгосон ХКОМ-ын кредитийн холбогдох зохицуулалтыг Монголын талаас хийх бөгөөд олон улсын ялгарлыг бууруулах зорилт болон Монгол Улсын тодорхойлсон бусад зорилтын хүрээнд кредитийг ашиглахыг зөвшөөрнө.

49. Тал тус бүр кредит олголт болон кредитийн хэрэглээг хянаж явах бөгөөд энэхүү журмын 17 болон 45 дугаар зүйлүүдэд заасны дагуу давхар тоолохоос сэргийлнэ.

Q. Бусад

50. 2013 оны 1 дүгээр сарын 1 гэхэд эсвэл үүнээс хойш хэрэгжиж эхэлсэн төслийг ХКОМ-ын төсөл гэж үзнэ.

51. ХКОМ нь 2030 он хүртэл ХКОМ-ын хүрээнд хэрэгжих хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах эсвэл ангижруулах төслүүдээс баталгаажсан ялгарлын бууралтын хугацааг хамарна. Хоёр тал дээр дурдсан хугацааг сунгах боломжийг судлан 2030 он гэхэд тодорхой шийдвэрт хүрнэ.